

hr.hdc.gov.mn ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН САН
ПРОГРАММААР ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ ӨГӨХ ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТНИЙ ЗААВАР

1. Hr.hdc.gov.mn буюу Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан программд бүртгэлээ үүсгэнэ. Бүртгэл үүсгэхдээ заавал **жи мэйл** хийх бөгөөд нууц үгээ мартсан тохиолдолд жи мэйлээр нууц үгээ сэргээж авна.
2. Hr.hdc.gov.mn буюу Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан программд нэвтэрч орно.
Нэвтрэх нэр: Регистрийн дугаар
Нууц үг: Бүртгэл үүсгэхдээ хийсэн нууц үг байна.
3. Нэвтэрч орсны дараа программын баруун дээд буланд байрлах өөрийн нэр дээр дарж **МИНИЙ МЭДЭЭЛЭЛ** хэсэгт орно.
4. **МЭРГЭЖИЛ** хэсгээ бөглөнө. Бакалавр, үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил, дээшлүүлэх гэх мэт мэргэжлээ бөглөөд хавсралт хэсэгт дипломуудаа оруулна.
5. **АЖЛЫН ТУРШЛАГА** хэсгээ бөглөх, диплом авсан цагаасаа эхлэн бүх ажилласан ажлын туршлагаа бөглөж оруулаад сүүлд ажиллаж байгаа ажлын туршлагаа ажиллаж буй байгууллагын хүний нөөцөд хэлж баталгаажуулна.
6. **БОЛОВСРОЛ** хэсгээ бөглөх ба боловсролын дипломоо хавсралт хэсэгт оруулна.
7. **ЗЭРЭГ** хэсгээ бөглөх ба ахлах, тэргүүлэх, зөвлөх гэх мэт мэргэжлийн зэргээ оруулна.
8. **ЗАРЛАЛ** хэсгийн **ШАЛГАЛТЫН ЗАР** хэсэгт орж **ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ АЖИЛЛАГСАД** хэсгээ дээрээ дарж мэргэжлээ сонгож шалгалтад бүртгүүлнэ. Төлбөрөө **QRay** ашиглан төлснөөр таны шалгалтад орох эрх үүснэ.
9. Шалгалтын товлолт өдрөө **МИНИЙ МЭДЭЭЛЭЛ**-ийн **ШАЛГАЛТ**-руу орж шалгалтаа өгөх бөгөөд 70-аас дээш оноо авч тэнцсэн тохиолдолд **ЛИЦЕНЗ** хэсэгт байх **ЛИЦЕНЗИЙН ХҮСЭЛТ** хэсэг рүү орж **ШАЛГАЛТ** гэсэн сонголтоор лицензийн хүсэлтээ илгээж **QRay** ашиглан төлбөрөө төлнө.